


Хамгаалалтын бүс

Усны тухай хуулийн 22.4 дэх хэсгийг үндэслэн усны эх, ундарга, нөөцийг хомстох, бохирдохоос хамгаалах, хүн амыг үер усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт тогтоох онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн зааг, эдгээр бүсэд мөрдөх дэглэмийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалын хавсралтад агуулагдах журмаар зохицуулагддаг байна.

Улз голын дагуу онцгой хамгаалалтын бүсийг журмын 2.3.2-д заасны дагуу гол мөрөн, горхи, булаг, шандны эргээс 50 метрээс доошгүй зайд буюу түүнээс өргөн, намаг бүхий татамтай тохиолдолд нийт татмын хэмжээгээр өргөсгөж, 2.3.3-д заасанчлан нуур, урсцын тохируулгатай усан сангийн эргээс 100 метр зайд, гол мөрөн дээр байгуулсан усан сангийн хувьд түүний эргээс тухайн гол мөрний онцгой хамгаалалтын бүсийн өргөнтэй тэнцүү хэмжээний зайд, 2.3.4-д заасанчлан хот суурин газрын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс 100 метрээс доошгүй, үерийн хамгаалалтын далангаас 50 метрээс доошгүй зайтайгаар тус тус зураглав.

Энгийн хамгаалалтын бүсийг тогтоохдоо тус журмын 2.6.1-д заасанчлан усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд, 2.6.2-д заасанчлан нийслэл болон аймгийн төвийн хот суурины нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс 500 метр хүртэлх зайд зураглав.



Зураг. Улз голын сав газрын усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн зураг

Газрын доорх усны хамгаалалтын бүсийг нөөц тогтоогдож тэжээгдэл, зөөгдөл, хуримтлалын мужууд зураглагдсан орд газруудад тогтоодог бөгөөд судалгаанд хамрагдаж буй сумуудын хувьд Дашбалбар сумын нутагт байрших Мардайн ордын усан хангамжийн зориулалтаар нарийвчилсан хайгуул хийж нөөц нь тогтоогдсон Сэвсүүлийн газрын доорх усны ордын хамгаалалтын бүсийг онцгой болон энгийн хамгаалалтын бүсээр ангилан зураглав. Журмын дагуу хамгаалалтын бүсүүдийг тогтооход сав газрын хэмжээнд усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой онцгой хамгаалалтын бүсэд 1207.03 км² газар нутаг, энгийн хамгаалалтын бүсэд 2570.52 км² газар тус тус хамаарч байна.

Усны нөөц, ус ашиглалтын салбарын ЭШДэА 3. Бямбасүрэн